

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 11.080.99

Эрүүл мэндийн зориулалттай нэг удаагийн хэрэгсэл. 2-р хэсэг. Амны хаалт. Техникийн шаардлага	MNS 6623-2:2016
Single use of medical device. Part 2. Mask. Technical requirement	

Стандартчиллын зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Зорилго

Нэг удаагийн хэрэглээний болон эмнэлгийн мэс заслын зориулалттай амны хаалт (цаашид "амны хаалт" гэх)-ны чанарын үзүүлэлт, шаардлагын хэм хэмжээг тогтооход оршино.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь нэг удаагийн хэрэглээний болон эмнэлгийн зориулалттай ариун мэс заслын амны хаалтны чанарыг шинжлэх, баталгаажуулах, хаяглах, савлах, хадгалах, тээвэрлэхэд тавигдах шаардлагыг тогтооход хэрэглэнэ.

3 Норматив ишлэл

Энэ стандартад иш татаж хэрэглэсэн дараах стандарт болон норматив техникийн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- FZ/T64005-2011 "Нэхээсгүй давууны техникийн үзүүлэлт" БНХАУ-ын стандарт
- GB 15979-2005 Нэг удаагийн хэрэглээний эрүүл ахуйн ариун бүтээгдэхүүний стандарт
- GB/T 24218.2-2009 "Нэхээсгүй даавуунд хийх туршилтын арга 1-р хэсэг: Нэгж талбайн чанарыг тодорхойлох" БНХАУ-ын стандарт
- YZB/Shanghai 0335-2005 Нэг удаагийн хэрэглээний эмнэлгийн ариутгасан амны хаалтны стандарт
- Монгол Улсын Үндэсний фармакопей 2011, Микробиологийн цэвэршилтийн зэрэглэл тогтоох аргууд
- АНУ-ын фармакопей – 2009

4 Нэр томъёо, тодорхойлолт

4.1

Нэг удаагийн хэрэглээний амны хаалт

Гадна орчин болон орчны халдвар, бохирдлоос хамгаалах, тусгаарлах, эрүүл ахуй, халдвар хамгааллыг сахиж хамар амыг хааж хэрэглэх хэрэгсэл.

4.2

Мэс заслын ариун амны хаалт

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдэд мэс ажиллагааны явц болон дараа агаар замаар халдвар дамжихаас хамгаалах, эрсдлийг бууруулах, орчны ариун байдлыг хадгалж хамар амыг хааж хэрэглэх хэрэгсэл.

5 Ерөнхий шаардлага

5.1 Амны хаалтыг бүчний төрлөөр нь А болон В хэлбэрийн гэж ангилна. А хэлбэрийн амны хаалтны бүч нь чихэндээ угладаг бол В хэлбэрийн амны хаалт нь уях бүчтэй байна.

5.2 Амны хаалтны их бие нь тэгш өнцөгт хэлбэртэй, гадна дотор талууд нь цайвар өнгөтэй, дунд давхарга нь цаасан шүүлтүүр байх ба дөрвөн захыг халуун даралтаар нааж тэгшилсэн, урагдаж гэмтээгүй, өнгө алдаагүй байна.

5.3 Амны хаалтанд орох нэхээсгүй материалуудын чанарын хувьд FZ/T64005-2011 стандартад эсвэл дүйцэхүйц олон улсын бусад стандартад нийцсэн байна.

1-р хүснэгт

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Норматив бичиг баримт
1	Гадна, дотно нэхээсгүй даавуу	-FZ/T64005-2011 стандарт, хүснэгт 1,2 -н дагуу -GB/T24218.1-2009 "Нэхээсгүй даавуунд хийх туршилтын арга 1-р хэсэг: Нэгж талбайн чанарыг буюу нягтыг тодорхойлох"
2	Дунд давхаргын шүүлтүүрэн нэхээсгүй даавуу	-FZ/T64005-2011 стандарт, хүснэгт 1,2 -н дагуу -GB/T24218.2-2009 "Нэхээсгүй даавуунд хийх туршилтын арга 1-р хэсэг: Нэгж талбайн чанарыг тодорхойлох"

5.4 Амны хаалтанд хамрын уян даруулгыг заавал хийсэн байна. Хамрын уян даруулга нь нугалардаг, хөнгөн цагаан материал байна.

5.5 Мэс заслын амны хаалт нь даралтат уурын аргаар ариутгасан байх ба ариун чанарыг үзэж шалгана.

5.6 Үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан журмын дагуу тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны болон эрүүл ахуйн байгууллагаас зөвшөөрсөн цэгт хаях ажлыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

6 Амны хаалтны чанарын үзүүлэлт шаардлага

6.1 Амны хаалтын хэмжээ нь 2-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

2-р хүснэгт

Үзүүлэлт	Ангилал	Хэмжээ (см)	Зөвшөөрөгдөх хэлбэлзэл хэмжээ (см)
Хэмжээс	Их бие	Урт 18,0 x Өргөн 9,5	±0,5
Бүч	А хэлбэр буюу угладаг	17,5 x 2	±5
	В хэлбэр буюу уядаг	≥20 x 4	±5

6.2 Амны хаалтны чанарын үзүүлэлт нь 3-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

3-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт	Шинжилгээний арга	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Гадна байдал	Мэдрэхүйн арга	Амны хаалтны гадаргуу нь цэвэр, урагдал гэмтэлгүй байна.
2	Наалтны жигд байдал	Мэдрэхүйн эрхтэнээр	Наалт нь бүх хэсэгт жигд, салаагүй байна
3	Материалын нягтын чанарын үзүүлэлт	Жингийн арга	Гадна дотор талууд нь 18 г/м ² -аас багагүй Дунд давхарга нь 20 г/м ² -аас багагүй
4	Уян даруулгын хэмжээ	Хэмжих арга	Урт нь 8 см-ээс багагүй
Нэг удаагийн амны хаалтны микробиологийн цэвэршилтийн үзүүлэлт			
5	Агаартан бактерийн нийт тоо	Микробиологийн арга	2х10 ² КҮН/г-аас ихгүй
6	Хөгц мөөгөнцрийн нийт тоо	Микробиологийн арга	10 ² КҮН/г-аас ихгүй
7	<i>Coliform Bacteria</i>	Микробиологийн арга	Илрэх ёсгүй
8	<i>Staphylococcus aureus</i>	Микробиологийн арга	Илрэх ёсгүй
9	<i>Pseudomonas aeruginosa</i>	Микробиологийн арга	Илрэх ёсгүй
Мэс заслын ариутгасан амны хаалтны цэвэршилтийн үзүүлэлт			
10	Ариун чанар	Микробиологийн арга	Ариун чанартай

7 Шалгах арга дараалал

7.1 Хэмжээ

Амны хаалтны их биений дундаж хэмжээ, уян даруулгын урт болон бүчний уртыг нийтлэг хэрэглэгддэг хэмжилтийн багаж хэрэгсэл ашиглаж тодорхойлно.

7.2 Гадна байдал

Амны хаалтны гадна байдлыг мэдрэхүйн эрхтэнээр харж шалгана.

7.3 Наалтны нэгэн жигд байдал

Дээжид авах хэмжээ нь нийт нэг багцын 3 хувьтай тэнцэх бүтээдэхүүн байх ба түүнээс 3-аас багагүй боодлыг түүвэрлэн авна. Нэг боодол материалаас гарах бүтээгдэхүүний тоог нэг багц гэж үзнэ.

7.4 Материалын нягтын чанарын үзүүлэлт

Нэг боодол материалаас 1 м² хэмжээс бүхий гурван хэсэг материалыг түүвэрлэн сонгон авч тус бүрийг жинлэн дунджаар материалын нягтыг тооцно.

$$q = \frac{g}{m_2}$$

Үүнд:

q –материалын нягт

g – материалын жин

m_2 –материалын хэмжээ

7.5 Микробиологийн цэвэршилт

Дээж авах:

Дээжид авах хэмжээ нь нийт нэг багцын 3 хувьтай тэнцэх бүтээдэхүүн байх ба түүнээс 10-аас багагүй ширхэгийг түүвэрлэн авна. Авсан дээжний баглаа боодол бүтэн, шалгахын өмнө нээгээгүй байх шаардлагатай.

Шинжлэх уусмал бэлтгэх:

Дээрх дээжинд авсан бүтээгдэхүүнээс (10 ± 1) г-ийг хэмжин авч 200 мл натри хлорид пептоны уусмалд хийж, үндсэн уусмалыг бэлтгэнэ.

7.5.1 Агаартан бактерийн нийт тоог тодорхойлох

Бэлтгэсэн үндсэн уусмалаас 2 мл-ийг авч, 18 мл натри хлорид пептоны уусмалд хийж, 5 ширхэг Петрийн аяга тус бүрт тухайн уусмалаас 1 мл-ийг авч хийнэ. Ариутгаж, $(45-50)^\circ\text{C}$ хүртэл хөргөсөн *Plate Count Agar* эсвэл *Nutrient Agar*-аас $(15-20)$ мл-ийг нэмж, ёроолыг жигд бүрхтэл нь тойруулах хөдөлгөөнөөр тараан холиод, царцааж термостатын $(35 \pm 1)^\circ\text{C}$ -д 3-аас 5 хоног тавьж өсгөвөрлөнө.

Сөрөг хяналт:

Шинжилгээнд хэрэглэж буй тэжээлт орчноос $(15-20)$ мл-ийг ариун Петрийн аяганд савлаж шинжилж буй дээжтэй зэрэгцүүлэн тэжээлт орчны хяналтыг тавина. Хэрэв сөрөг хяналтанд ургалт илэрвэл шинжилгээг дахин давтан хийнэ.

Үр дүнг тооцох:

Шинжилгээ хийсэн дээжийг сөрөг хяналттай харьцуулж, үр дүнгээ тооцно. Сөрөг хяналт бактерийн ургалтгүй тохиолдолд, Петрийн аягатай тэжээлт орчинд ургасан колоний нийт тоог колони тоологчоор тоолж, 1 г бүтээгдэхүүнд байгаа агаартан бактерийн нийт тоог олох ба дараах томъёог ашиглана.

$$X = \frac{(\alpha_1 + \alpha_2)}{2} \times 10^n$$

Энд:

X – Бактерийн нийт тоо

α_1 – I Петрийн аяганд ургасан колоний тоо

α_2 – II Петрийн аяганд ургасан колоний тоо

10^n – Шингэрүүлэгийн зэрэг

2 – Петрийн аяганы тоо

7.5.2 Хөгц,мөөгөнцрийн нийт тоог тодорхойлох

7.5.1-д бэлтгэсэн шингэрүүлэгээс авч, ариун 5 ширхэг Петрийн аяга тус бүрт 1 мл-ийг хийнэ. Ариутгаж, $(45-50)^\circ\text{C}$ хүртэл хөргөсөн *Sabouraud Dextrose Agar* эсвэл *Czapek Dox agar*-с $(15-20)$ мл-ийг хийж таглан, ёроолыг жигд бүрхэн тархтал нь тойруулах хөдөлгөөнөөр тараан хольж, царцахаар Петрийн аягыг хөмөрч термостатын $(35 \pm 1)^\circ\text{C}$ -д 5-аас 7 хоног өсгөвөрлөнө.

Сөрөг хяналт:

Шинжилгээнд хэрэглэж буй тэжээлт орчноос $(15-20)$ мл-ийг ариун Петрийн аяганд савлаж, шинжилж буй дээжтэй зэрэгцүүлэн тэжээлт орчны хяналтыг тавина. Хэрэв сөрөг хяналтанд ургалт илэрвэл шинжилгээг даван хийнэ.

Үр дүнг тооцох:

Шинжилгээ хийсэн дээжийг сөрөг хяналттай харьцуулж, үр дүнгээ тооцно.

Сөрөг хяналтанд хөгц, мөөгөнцрийн ургалтгүй тохиолдолд Петрийн аягатай тэжээлт орчинд ургасан колоний тоог тоолж 1 г бүтээгдэхүүнд байгаа хөгц мөөгөнцрийн нийт тоог олох ба дараах томъёог ашиглана.

$$X = \frac{(\alpha_1 + \alpha_2)}{2} \times 10^n$$

Энд:

X – Хөгц,мөөгөнцрийн нийт тоо

α_1 – I Петрийн аяганд ургасан колоний тоо

α_2 – II Петрийн аяганд ургасан колоний тоо

10^n – Шингэрүүлэгийн зэрэг

2 – Петрийн аяганы тоо

7.5.3 *Coliform* бактерийг илрүүлэх:

Үндсэн уусмалаас 5 мл-ийг хэмжин авч, 50 мл "ECBroth"-н баяжуулах тэжээлт орчинд хийж термостатын (35±1) °C-д (24-48) цаг тавьж өсгөвөрлөнө. Дээрх баяжуулах тэжээлт орчинд бактерийн ургалт илэрвэл цэвэр өсгөвөр ялгахад "Endo Agar" эсвэл "Macconkey Agar"-ийн аль нэгэнд сэлгүүлэн тарьж, термостатын (35±1) °C-д (18-24) цаг өсгөвөрлөнө.

Дээрх сонгомол тэжээлт орчинд лактозыг задлан хүчил үүсгэж, орчны pH өөрчлөгдөн "улаан" өнгөтэй колони эсвэл "улаан өнгийн тунадас"-аар хүрээлэгдсэн колони ургасан байвал "Coliform" бактер илэрсэн байна гэж тооцно.

Дараа нь биохимийн сорилын ялган дүйх шинжилгээг хийж "Coliform" бактер болохыг баталгаажуулна.

Хэрэв дээрх хэв шинжит колоний ургалтгүй, баталгаажуулан ялган дүйх "биохими"-ийн сорилоор "эрэг" үзүүлэлт илрээгүй байвал дээжинд "Coliform" бактер илрээгүй байна гэж тооцно.

7.5.4 *Staphylococcus aureus* бактерийг илрүүлэх:

Үндсэн уусмалаас 5 мл-ийг хэмжин авч, 50 мл Mannitol Salt Medium, Thioglycollate Medium-н тэжээлт орчны аль нэгэнд хийж, термостатын (35±1) °C-д (24-48) цаг өсгөвөрлөнө. Дээж таригдсан шингэн тэжээлт орчинг жигд булингартуулсан ургалт илэрвэл цэвэр өсгөвөр ялгахад Baird-Parker Agar эсвэл Mannitol Salt Agar-т сэлгүүлэн тарьж, термостатын (35±1) °C-д (18-24) цаг өсгөвөрлөхөд Baird-Parker Agar дээр хар өнгөтэй төвгөр, гөлгөр, колоний эргэн тойронд мананцар үүсгэсэн колони ургасан, Mannitol Salt Agar-т маннигын задалж алтлаг шар өнгө үүсгэсэн колони өсгөвөрлөгдсөн ургалт илэрсэн байвал биохимийн нэмэлт батлах сорил болох катаказын сорил, "сийвэн бүлэгнүүлэх", цус задлах идэвхи тодорхойлох болон наалдац бэлдэн морфологи шинж тодорхойлох сорилтуудыг хийж өсгөвөрлөн ялган дүйх тодорхойлно.

(Монгол улсын Үндэсний Фармакопейн Өгүүлэл 597-598 дугаар хуудас)

7.5.5 *Pseudomonas aeruginosa* бактерийг илрүүлэх:

Үндсэн уусмалаас 5 мл-г хэмжин авч, 50мл Cetrimide Medium тэжээлт орчинд хийж термостатын (35±1) °C-т (24-48) цаг тавьж өсгөвөрлөнө.

Бактерийн ургалт илэрвэл цэвэр өсгөвөр ялгахад сонгомол тэжээлт орчин "Cetrimide Agar"-д сэлгүүлэн тарьж, термостатын (35±1) °C-т (18-24) цаг өсгөвөрлөхөд "Cetrimide Agar" дээр "хөх ногоон нөсөө" бүхий анхилам үнэртэй колони ургасан байвал баталгаажуулах нэмэлт сорил катализа, оксидаза сорил хийж, хөх ногоовтор өнгөтэй колониос наалдац бэлдэн грамаар будаж микроскопоор харж морфологи шинжийг тодорхойлно.

(Монгол улсын Үндэсний Фармакопейн Өгүүлэл- 597-598 дугаар хуудас)

7.6 Микробиологийн цэвэршилт тодорхойлох хурдавчилсан арга (Rida count)

Энэ аргыг амны хаалтын материал болон ариутгагдаагүй амны хаалтанд агаартан бактер, хөгц мөөгөнцөрийн тоо тодорхойлох болон эмгэг төрөгч Coliform, Staphylococcus aureus бактер илрүүлэх шинжилгээнд ашиглана.

Шинжилгээнд бэлтгэх:

Ялтасан тэжээл дээр ариун 0,9 %-ийн натри хлоридын ариутгасан уусмалыг 1 мл дусааж, шингэнийг бүрэн шингэсний дараа тунгалаг бүрхүүлийг хааж, тасалгааны хэмд 15 мин тавина.

Ялтасан тэжээлийн тунгалаг хальсан дээр дээжний талаарх мэдээллийг бичнэ.

7.6.1 Агаартан бактерийн нийт тоо тодорхойлох:

Ялтсан тэжээл "*Rida count Total*" (Aerobic count)-н тунгалаг бүрхүүлийг сөхөн бэлэн тэжээлт орчинтой хэсгийг, шинжлэх дээжийн гадаргуугийн 100 мм² талбайд зөөлөн дарж, дээж болгон авна.

Тунгалаг бүрхүүлийг хааж, термостатын (35±1) °C-д (24-48) цаг тавьж өсгөвөрлөнө.

Үр дүнг тооцох:

Ялтсан тэжээл дээр ургасан улаан өнгөтэй колоний тоог тоолж 100 мм²-д байгаа агаартан бактерийн нийт тоог тооцно.

Хөгц, мөөгөнцөрийн нийт тоо тодорхойлох:

Урьдчилан бэлтгэсэн ялтсан тэжээл "*Rida count Yeast & Mold*"-н тунгалаг бүрхүүлийг сөхөж, сөхсөн тэжээлт орчинтой хэсгийг шинжлэх дээжийн гадаргуугийн 100 мм² талбайд зөөлөн дарж, дээж болгон авна.

Тунгалаг бүрхүүлийг хааж, термостатын (22-25) °C-д 2-оос 5 хоног тавьж өсгөвөрлөнө.

Үр дүнг тооцох:

Ялтсан тэжээл дээр ургасан хөх ногоон эсвэл хөх ногоон туяатай цагаан өнгөтэй колоний тоог тоолж 100 мм²-д байгаа хөгц, мөөгөнцөрийн нийт тоог тооцно.

7.6.2 *Coliform* бактерийг илрүүлэх:

Урьдчилан бэлтгэсэн ялтсан тэжээл "*Rida count Coliform*"-н тунгалаг бүрхүүлийг сөхөж, сөхсөн тэжээлт орчинтой хэсгийг шинжлэх дээжийн гадаргуугийн 100 мм² талбайд зөөлөн дарж, дээж болгон авна.

Тунгалаг бүрхүүлийг хааж, термостатын (35±1) °C-д (24-48) цаг тавьж өсгөвөрлөнө.

Үр дүнг тооцох:

Ялтсан тэжээл дээр цайвар хөх, цайвар ногоон, (гүн цэнхэр-*E.Coli*) өнгөтэй колони ургасан бол *Coliform* бактери илэрсэн байна гэж тооцно.

Хэрэв дээрх хэв шинжит колоний ургалтгүй, байвал "*Coliform*" бактер илрээгүй байна гэж тооцно.

***Staphylococcus aureus* бактерийг илрүүлэх:**

Урьдчилан бэлтгэсэн ялтсан тэжээл "*Rida count Staph.aureus*"-н тунгалаг бүрхүүлийг сөхөж, сөхсөн тэжээлт орчинтой хэсгийг, шинжлэх дээжийн гадаргуугийн 100 мм² талбайд зөөлөн дарж дээж болгон авна.

Тунгалаг бүрхүүлийг хааж, термостатын (35±1) °C-д (24-48) цаг тавьж өсгөвөрлөнө.

Үр дүнг тооцох:

Ялтсан тэжээл дээр хөх ногоон өнгөтэй колони ургасан бол *Staphylococcus aureus* бактери илэрсэн байна гэж тооцно.

Хэрэв дээрх хэв шинжит колонийн ургалтгүй байвал "*Staphylococcus aureus*" бактер илрээгүй байна гэж тооцно.

7.7 Ариун чанар тодорхойлох:

Дээж авах

Ариутгал хийсэн тохиолдол бүрээс автоклавын (дээд, дунд, доод) 3 хэсэг дэх байрлал тус бүрээс 10 ширхэгийг ариун саванд авна. Давтан хийх шинжилгээнд дээжийг авахдаа шинжлэгдэхүүний хэмжээг 2 дахин нэмэгдүүлэн авна.

Ариун чанар шалгах:

Ариун өрөөнд ариутгасан амны хаалтаас 10 см²-аас ихгүйг ариун хайчаар хайчлан авч ариун хямсаагаар "*Thioglycollate Medium* 100 мл, *Sabouraud Dextrose Broth* эсвэл *Casein soya bean digest broth*" 100мл тэжээлт орчинд хийж, термостатын (35±1) °C болон 25°C-д 10-аас 14 хоног тавьж өсгөвөрлөнө. Бэлэн тэжээлт орчин ашиглаж буй үед үйлдвэрлэгчийн дагаж ирүүлсэн зааврын дагуу ашиглана. Цаашид Монгол Улсын Үндэсний Фармакопейн "Ариун чанар" тодорхойлох (хуудас 611) аргын дагуу тодорхойлно.

Сөрөг хяналт:

Шинжилгээнд хэрэглэж буй 100 мл савлагдсан 2 төрлийн тэжээлт орчноос хяналт болгон авч, шинжлэж буй дээрх дээжтэй зэрэгцүүлэн тавьж өсгөвөрлөнө. Хэрэв сөрөг хяналтанд ургалт илэрвэл шинжилгээг давтан дахин хийнэ.

8 Савлалт, хаяглалт, хадгалалт, тээвэрлэлт

8.1 Амны хаалтыг 50 ширхэгээр цаасан хайрцагт савлаж, хайрцган дээр дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- Үйлдвэрийн нэр, хаяг;
- Бүтээгдэхүүний нэр;
- Цувралын дугаар;
- Тоо хэмжээ;
- Стандартын дугаар;
- "Нэг удаа хэрэглэх" гэсэн тайлбар тэмдэглэгээ;
- Савлагчийн дугаар;
- Үйлдвэрлэсэн огноо;
- Хадгалах хугацаа;

8.2 Ариутгалтай амны хаалтыг 10 ширхэгээс дээшгүй байхаар зориулалтын уутанд савлана. Савлагаа нь дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- Үйлдвэрийн нэр, хаяг;
- Бүтээгдэхүүний нэр;
- Цувралын дугаар;
- Тоо хэмжээ;
- Стандартын дугаар;
- "Нэг удаа хэрэглэх" гэсэн тайлбар тэмдэглэгээ;
- "Ариун" гэсэн тэмдэглэгээ ба ариутгалын арга;
- Савлагчийн дугаар;
- Үйлдвэрлэсэн огноо;
- Хадгалах хугацаа;

8.3 Савласан амны хаалтыг зориулалтын зузаан цаасан хайрцагт савлаж дараах мэдээллийг агуулсан хаягтай байна. Үүнд:

- Үйлдвэрийн нэр, хаяг;
- Бүтээгдэхүүний нэр;
- Цувралын дугаар;
- Тоо хэмжээ;
- Үйлдвэрлэсэн огноо;
- Хадгалах хугацаа;

8.4 Хадгалалт

Амны хаалтны сав баглаа, боодлын битүүмжлэл алдагдаагүй тохиолдолд ариутгалын хугацаа нь 2 жил хүчинтэй байна. Савласан бүтээгдэхүүнийг хадгалах явцад салхи оруулахаар, хуурай цэвэр газар хадгална.

8.5 Тээвэрлэлт

Савласан бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдлыг ханган, чийг тоосноос хамгаалж зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.